



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 8/85

Мандалговь

Г.X.Намуунзулыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хяналт, шинжилгээ үнэлгээ, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2023 оны 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Хүүхэнхүү овогтой Намуунзуул 73.6 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа X.Намуунзулын холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг Салбар зөвлөлийн ажлын албананд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН УҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь
салбар зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын
14-ны өдрийн 10 дугаар тогтоолын хавсралт



**Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын
Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн сан хариуцсан
мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлсэн
Х.Намуунзул тухай дүгнэлт**

1. Х.Намуунзул нь 1999 онд Дундговь аймгийн Сайнцагаан суманд төрсөн. 24 настай, эмэгтэй.
2. Боловсрол: 2017-2021 онд МУИС-ийг төрийн удирдлага мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн.
3. Х.Намуунзулын тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ